

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны ... дугаар сарын-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Шаардлага шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэг, 22.9.2, 22.9.10 дахь заалт, 22.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2-д заасан “ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах”, 22.9.10-д заасан “Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа”-ны хүрээнд албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хавсралтаар баталсугай.

2.Татварын албатай тухай бүр мэдээлэл харилцан солилцож, гүйцэтгэл, үр дүнг хариуцан ажиллахыг Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ж.Энхтөр)-т даалгасугай.

3.Тушаалын хавсралтаар баталсан албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг олон нийтэд сурталчлан таниулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Мөнгөнтуул)-т үүрэг болгосугай.

4. Албан татварын хөнгөлөлтөд хамрагдах аж ахуйн нэгжийн шаардлага, стандартыг хангасан эсэхийг хянан баталгаажуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж ажиллуулахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Даваажаргал)-д үүрэг болгосугай.

5.Албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны статистик мэдээллийг нэгтгэн хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Цахимжилт, их өгөгдлийн хэлтэс (Ц.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Даваажаргал)-д даалгасугай.

7. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/67 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Т.АУБАКИР

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ
ЭДЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2, 22.9.10-д заасан албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг тодорхойлох, түүнд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү шаардлага, стандартыг баримтална.

Хоёр. Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

2.1.Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1.татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрийн, эсхүл өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;

2.1.2. татвар төлөгчийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1, 8.5-д заасан үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;

2.1.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д заасан хөрөнгө оруулалт оруулах шийдвэр гаргасан байх;

2.1.4. татвар төлөгч нь хөрөнгө оруулалт авч буй талтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.1.5. хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;

2.1.6. хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хамгааллын талаарх хууль тогтоомж, төрийн бодлоготой нийцсэн байх;

2.1.7. шинээр барьж байгуулах, засварлах, өргөтгөх, тохижилт хийх үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага, онцлогт нийцсэн түгээмэл загвар бүхий зураг төсөлтэй байхаас гадна, тэгш хүртээмжтэй ашиглах боломжтой байх;

2.1.8. хандив тусламжаар нийлүүлж буй тохижилт, тоног төхөөрөмж нь стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологитай байх.

2.2.Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив нь дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1.хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет хөрөнгө байх;

2.2.2.санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авч буй этгээд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив олгох татвар төлөгчтэй харилцан хамааралгүй байх;

2.2.3. Иргэний хуульд заасныг баримтлан санхүүгийн дэмжлэг, хандивын тусгай зориулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д нийцүүлэн тусгасан гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.4. санхүүгийн дэмжлэг, хандив олгосон болон хүлээн авсан этгээд нь тухайн санхүүгийн дэмжлэг, хандивыг энэхүү шаардлагын 2.2.3-т заасан гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээг цуцлах болон татгалзахгүй тухайгаа илэрхийлсэн акт үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.5. санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх.

2.3. Энэ шаардлагын 2.1, 2.2-т заасан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан хасагдах зардлын шаардлагыг хангасан байна.

2.4. Бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа нь хавсралтад заасан шаардлага, стандартыг хангасан байна.

Гурав. Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа

3.1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа нь дараах чиглэлтэй байна.

- 3.1.1. Хүүхдийн эрхийг хангах;
- 3.1.2. Хүүхдийн эрхийг хамгаалах;
- 3.1.3. Хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулах, ашиглах;
- 3.1.4. Хүүхдийн зуслан барьж байгуулах, ашиглах;
- 3.1.5. Хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах;
- 3.1.6. Ахмад настны төрөлжсэн асрамж, үйлчилгээний төвийн үйл ажиллагааг дэмжих;
- 3.1.7. Ахмад настны эрхийг хангах;
- 3.1.8. Ахмад настны эрхийг хамгаалах;
- 3.1.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйл ажиллагааг дэмжих;
- 3.1.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах;
- 3.1.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах;
- 3.1.12. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх;
- 3.1.13. Хүүхдийн төлөө санд олгох санхүүгийн дэмжлэг, хандив;
- 3.1.14. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд олгох санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2. Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээ нь дараах төрөлтэй байна.

3.2.1. Хүүхдийн эрхийг хангах хүрээнд:

3.2.1.1. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 8.1.1-т заасан арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэхэд зориулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.1.2. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12.1.5-д заасан хүүхдийн санаачилсан шинэ бүтээл, урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон амжилт гаргасан хүүхдэд олгосон хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.2. Хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд:

3.2.2.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.1.4-т заасны дагуу өгсөн санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.2.2. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан орчин нөхцлийг бүрдүүлэхэд зориулсан бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагаанд олгосон хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.2.3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.2-д заасан үйл ажиллагаа, үйлчилгээнд зориулсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.2.4. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.7-д заасан бүтэн өнчин хүүхдийг бие даан амьдрах хөтөлбөрт хамруулахад олгосон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.3. Хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулах, ашиглах хүрээнд хийсэн бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагаанд олгосон хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.4. Хүүхдийн зуслан барьж байгуулах, ашиглах хүрээнд хийсэн бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагаанд олгосон хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.5. Хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах хүрээнд хийсэн бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагаанд олгосон хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.6. Ахмад настны төрөлжсөн асрамж, үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд:

3.2.6.1. ахмад настанд зориулсан төрөлжсөн асрамжийн газар шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.6.2. ахмад настны асрамжийн газар, идэвхтэй насжилтыг дэмжих төв, асаргааны хувилбарт үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.6.3. ахмад настны асрамжийн төвийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтад зориулсан санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.7. Ахмад настны эрхийг хангах хүрээнд:

3.2.7.1. ахмад настны эрхийг хангах хүрээнд чиглэсэн аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.7.2. ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.7.3. ахмад настны эрх ашгийг хангах зорилготой хурал, зөвлөгөөний үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.7.4 ахмад настны талаарх хууль эрх зүйн орчинг сайжруулах, судалгааны ажилд зориулсан санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.7.5. асрамж халамжийн төвөөс гарсан, гэр оронгүй ахмад настанг гэр оронтой болгох, гэр хороололд амьдарч байгаа ахмад настанд олгосон орон сууц болон орон сууцны түрээсийн зардлын санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.8. Ахмад настны эрхийг хамгаалах хүрээнд:

3.2.8.1. ахмад настны эрхийг хамгаалахад чиглэсэн аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.8.2. ахмад настанд зориулсан чөлөөт цагийн талбай, цэцэрлэгт хүрээлэн шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.8.3. ахмад настны хөгжил, оролцоог дэмжих арга хэмжээ, үйлчилгээ, үйл ажиллагаанд олгосон санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.8.4. Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх Ахмадын санд олгосон санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд:

3.2.9.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан асрамжийн газар шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив;

3.2.9.2. асрамж халамжийн төв, гэр хороололд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах, орон сууцны түрээсийн зардлын дэмжлэг үзүүлэх.

3.2.10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хүрээнд:

3.2.10.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах зорилготой хурал, зөвлөгөөний үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.2.10.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, хөгжлийг дэмжих хүрээнд хөгжлийн төвийн байраар хангах;

3.2.10.1. хөгжлийн бэрхшээлтэй хүн боловсрол эзэмшихэд тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийн санхүүгийн дэмжлэг, хандив үзүүлэх;

3.2.10.3. хууль эрх зүйн орчинг сайжруулах, судалгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.2.11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах хүрээнд:

3.2.11.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх орчин үеийн дэвшилтэт технологи бүхий туслах хэрэгсэл, протез, ортопед худалдан авахад санхүүгийн дэмжлэг, хандив үзүүлэх;

3.2.11.2. хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлэх, оношлох, эмчлэх дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.2.11.3. хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүүл мэндийн шалтгаанаар гадаад улсад эмчлүүлэхэд санхүүгийн дэмжлэг, хандив үзүүлэх;

3.2.11.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг олон улсын тэмцээн уралдаанд оролцоход санхүүгийн дэмжлэг, хандив үзүүлэх;

3.2.11.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний бичил бизнесийг дэмжих хүрээнд тоног төхөөрөмж авахад санхүүгийн дэмжлэг, хандив үзүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах.

3.2.12. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх хүрээнд:

3.2.12.1. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагад хүүхэд зөөвөрлөх тусгай зориулалтын автобус, машинаар хангах.

3.2.13. Хүүхдийн төлөө санд олгох санхүүгийн дэмжлэг, хандивын хүрээнд:

3.2.13.1. Хүүхдийн төлөө санд олгосон биет болон биет бус хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, хандив.

3.2.14. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд олгох санхүүгийн дэмжлэг, хандивын хүрээнд:

3.2.14.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд олгосон санхүүгийн дэмжлэг, хандив.

3.3. Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд хүснэгт 1-д заасан бусад шаардлага, стандартыг хангасан байна.

Дөрөв. Бусад

4.1. Аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2, 22.9.10 дахь заалтыг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

4.2. Аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй нь тогтоогдсон тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

4.3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр татварын хөнгөлөлт эдлүүлэх үйл ажиллагааг хянан баталгаажуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулна.

4.4. Ажлын хэсэг нотлох баримтыг бүрдүүлэн дүгнэлт гаргах бөгөөд Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр аж ахуйн нэгжийн татварын хөнгөлөлт эдлэх хүсэлтийг баталгаажуулан тухай бүр татвар төлөгчийн харьяалах татварын албанд хүргүүлнэ.

4.5. Тухайн тайлант жилд урт хугацааны хөрөнгө оруулалт хийж хөнгөлөлтөд хамрагдах татвар төлөгчийн тайлант жилүүдийн зардлын дүн, төслийн гүйцэтгэлийг 4.3-д заасан Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн баталгаажуулалт хийж тухайн хүсэлт ирүүлсэн тухай бүрд Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

... оОо ...

**БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ТАВИГДАХ БУСАД ШААРДЛАГА, СТАНДАРТ**

№	Хуулийн заалт, чиглэл, зориулалт	Зорилго, үндэслэл	Холбогдох стандарт, журам	Тавигдах доод шаардлага	Тусгай шаардлага	Тайлбар
Нэг. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан төрөлжсөн асрамжийн газар шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх:						
1.1	Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.9 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2.3, 13.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.2 дахь хэсэг	Хүний эрхэд суурилсан асрамжийн үйлчилгээг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхдэд тэгш хүртээмжтэй хүргэх	Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5823:2016; Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандарт MNS 5897:2016; Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар, стандарт MNS6056:2009; Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны стандарт MNS6055:2009;	-Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн хөгжил, хамгааллын талаарх төрийн болон салбарын бодлогод нийцсэн байх; -Хандив тусламжаар нийлүүлж буй тохижилт, тоног төхөөрөмж нь стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн байх; -Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн алжаал ядаргааг тайлах, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх, урлаг спортоор хичээллэх зэрэг нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн байх; -Хүүхдийг хүлээн авах, хүүхэд амьдрах тав тухтай, шаардлага хангасан аюулгүй, орчныг бүрдүүлсэн байх;	- Бүтээн байгуулалтыг барьж, ашиглалтад орсны дараа үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх урт болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх; - Бүтээн байгуулалт нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн түгээмэл загвар бүхий зураг төсөлтэй байх; - Бүтээн байгуулалт нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд ээлтэй, стандарт шаардлагад нийцсэн, тэгш хүртээмжтэй ашиглах боломжтой байх; - Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд саадгүй чөлөөтэй зорчих, ашиглахад зориулагдсан туслах хэрэгсэл, тохируулгат орчин, хэрэглэгдэхүүнээр хангагдсан байх; - Бүтээн байгуулалт нь байгальд ээлтэй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй байх;	

			Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS5852:2017.	-Хүүхдүүдийг эрэгтэй, эмэгтэй хүйсээр нь ялгаатай өрөө, давхарт байрлуулахаар өрөө тасалгааны зохион байгуулалтыг төлөвлөсөн байх; -Халуун хүйтэн усаар хангагдсан, бохирын ус зайлуулах инженерийн шугамд холбогдсон буюу зөөврийн усан хангамжтай нөхцөлд нам даралтын зуухаар халаах эрүүл ахуйн шаардлага хангасан халуун хүйтэн усан сантай байх;	- Ашиг хонжоо олох эсхүл хүүхдийг ашиглах зорилго агуулаагүй байх; - Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөөтэй байх; - 10 хүүхдэд нэг шүршүүр, 6 эмэгтэй, 10 эрэгтэйд тус бүр нэг суултуур байх; - Нэг хүнд ноогдох унтлагын өрөөний талбайн хэмжээ 5м2-аас доошгүй буюу нэг өрөөнд 4-өөс ихгүй ахмад настан /хүүхэд байх; - Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан эмчилгээ, сувилгааны өрөөтэй байх.	
Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тохируулгат орчинг бүрдүүлэх, засварлах						
2.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцын 24 дүгээр зүйл; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль; Хөдөлмөрийн тухай хуулийн 144.6 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд саадгүй, тэгш хүртээмжтэй оролцох боломжийг хангах	Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар, стандарт MNS6056:2009; Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны стандарт MNS6055:2009.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тохируулгат орчинг бүрдүүлэх, засварлах үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, шаардлагад нийцсэн зураг төсөлтэй байх ба хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг тусгасан байна.	- Хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн төрөл, хэлбэр, хэрэгцээ шаардлага, онцлог, ялгаатай байдлыг харгалзан тохируулгат орчинг бүрдүүлсэн байх; - Тохируулгат орчинг бүрдүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрэгцээгээ хангах, сэтгэл ханамжтай байхад анхаарсан байх; - Тохируулгат орчны тохижилт, тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд нь чанар стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байх.	

Гурав. Хүүхдэд зориулсан амрах, сувилуулах, асруулах нийгэмшихэд чиглэсэн хүүхдийн зуслан, төв шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх

3.1	Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.2.дахь хэсэг	Хүүхдэд зориулсан амрах, сувилуулах, асруулах нийгэмшихэд чиглэсэн хүүхдийн зуслан шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэхэд тавигдах шаардлагыг тогтоох	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS5633:2023; Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны стандарт MNS6055:2009.	- Хүүхдийг хүлээн авах, хүүхэд амьдрах тав тухтай, шаардлага хангасан аюулгүй, орчныг бүрдүүлсэн байна; - Хүүхдийн зуслангийн бүс нь шатахуун түгээх газраас 2 км-ээс доошгүй зайд баригдсан байх; - Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөөтэй байх;	- Зуслангийн байр, зам, талбай нь тусгай хэрэгцээт хүүхэд амрах, зорчиход саадгүй байхаар тохижуулсан байх; - Зуслангийн бүс, барилга хооронд шөнийн гэрэлтүүлэг, камер байрлуулсан байна. Зуны зуслангийн байрны нэг хүүхдэд ноогдох өрөөний хэмжээ 5м2-аас доошгүй буюу нэг өрөөнд 4 хүүхэд байх.
-----	--	--	--	--	---

Дөрөв. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх

4.1	Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.2.дахь хэсэг; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;	Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийгмийн харилцаанд тэгш хүртээмжтэй оролцоход дэмжлэг үзүүлэх	Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага MNS6751:2019; Хүүхдийн тоглоомын талбай. MNS 6751:2019 Орон сууцны дотор, гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар,	- Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн нь хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн тэгш хүртээмжтэй, аюулгүй ашиглах боломжтой түгээмэл загвар бүхий орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх; - Гадаа тоглоомын талбайн хэмжээ 30м-ээс доошгүй байх бөгөөд хөдөлгөөнт тоглоомтой байх; - Цэцэрлэгт хүрээлэн, зам талбай нь тулгуур эрхтний бэрхшээлтэй хүнд зориулсан налуу зам хийх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан	- Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан автомашины зогсоолыг төлөвлөсөн байх; - Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнд хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, шаардлагад нийцсэн тохируулгат орчинг бүрдүүлсэн байх; - Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнд хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, шаардлагад нийцсэн таних тэмдэг, дуут дохио, мэдээллийн самбар, чиглүүлэгч зэргийг суурилуулсан байх ба энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг
-----	--	--	---	---	---

			<p>стандарт MNS6056:2009;</p> <p>Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны стандарт MNS6055:2009;</p> <p>Тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага, иж бүрэн гудамж UCS0902B:2022;</p> <p>БНБД 30.01.03, Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 31.03.03*/11 Олон нийтийн иргэний барилга</p>	<p>тохируулгат орчинг бүрдүүлсэн байх;</p> <p>- Тоглоомын талбай, задгай талбай, элсэн талбайтай, амрах хэсэгтэй байх;</p> <p>- Зураг төсөлтэй байх;</p>	<p>ялгаварлан гадуурхсан, тусгаарласан байхыг хориглоно;</p> <p>- Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнд гэнэтийн аваар ослын үед болон эрүүл мэндийн шалтгаанаар яаралтай тусламж дэмжлэг дуудахад зориулагдсан дуут болон гэрлэн дохиолол суурилуулсан байх;</p>	
Тав. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив, тусламж						
5.1	<p>Хүүхдийн эрхийн тухай хууль</p> <p>“Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”</p>	<p>Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам /Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоол/,</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж олгох журам /Засгийн газрын 2025</p>	<p>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгааллын талаарх төрийн болон салбарын бодлого, хууль тогтоомжид нийцсэн байх;</p> <p>- Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үзүүлэх хандив, санхүүгийн дэмжлэг нь</p>	<p>- Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үзүүлэх хандив, санхүүгийн дэмжлэг нь амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бодит дэмжлэг байх;</p> <p>- Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний</p>	

<p>Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний тавих нийтлэг шаардлага MNS 7076:2025 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц;</p> <p>Нийгмийн халамжийн тухай хууль;</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;</p> <p>Ахмад настны тухай хууль;</p> <p>Хөдөлмөрийн тухай хууль;</p> <p>Монгол улсын тусгай сангийн тухай хууль 21²-3 дахь хэсэг;</p> <p>Засгийн газрын 2019 оны 172 дугаар тогтоол</p>		<p>оны 117 дугаар тогтоол/</p>	<p>хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодит дэмжлэг байх;</p> <p>- Хандив тусламжаар нийлүүлж буй тохижилт, тоног төхөөрөмж нь стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага, орчин үеийн шинэ техник, технологид нийцсэн байх;</p> <p>- Эрүүл мэндийн чиглэлээр нийлүүлж буй тоног төхөөрөмж нь стандартад нийцсэн байх;</p>	<p>эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг, хандив, үйл ажиллагаа, үйлчилгээ нь аливаа болзол шалгуургүй, барьцаагүй, хүний эрхийг дээдэлсэн, сайн дурын үндсэн дээр хийгдсэн байх;</p>	
--	--	--------------------------------	---	--	--

---oOo---